



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2016 оны санхүүгийн үйл ажиллагааны тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36.12.5 дахь заалт, Удирдах зөвлөлийн 2017 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2016 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагааны тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан 2017 онд сургалт, судалгааны ажлын чанарт ахиц гарган, санхүүгийн үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлж, үргүй зардлыг бууруулан, хэмнэлттэй ажиллахыг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захирал /Б.Очирбат/, дэд захирал /Л.Пүрэв/ нарт даалгасугай.

ДАРГА  Н.БЭГЭ





ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот


Санал дэмжих тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12.1 дэх заалт, 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн Хамтын ажиллагааны санамж бичиг, Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2017 оны 50, Өмнөговь аймгийн Засаг даргын 1/443, 1/665 тоот албан бичиг, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2017 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд Өмнөговь аймгийн Политехникийн коллежийг түшиглэн бакалаврын хамтарсан хөтөлбөр /2+2/, ахисан түвшний хөтөлбөр хэрэгжүүлэх, цаашид ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль байгуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх саналыг дэмжин Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд тус тус уламжилсугай.

2. Хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх, бүрэлдэхүүн сургууль байгуулахтай холбоотой ажлыг зохих хууль, дүрэм журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захирал /Б.Очирбат/-д даалгасугай.

ДАРГА



Н.БЭГЗ



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

Дүрэм шинэчлэн батлах тухай


Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12.1 дахь заалт, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3.1.1 дэх заалт, Удирдах зөвлөлийн 2017 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн дүрмийг хавсралтаар шинэчлэн баталж, 2017 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс мөрдсүгэй.

2. Батлагдсан дүрмийг мөрдөж, биелэлтэд хяналт тавьж ажиллах, дүрэмд нийцүүлж 2017 оны 7 дугаар сарын 01-ний дотор сургуулийн дотоод үйл ажиллагаатай холбоотой журамд өөрчлөлт оруулж батлан хэрэгжүүлэхийг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захирал /Б.Очирбат/-д даалгасугай.

3. Энэхүү дүрэм батлагдсантай холбогдуулан Удирдах зөвлөлийн 2014 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн 06 тоот тогтоолоор батлагдсан “ШУТИС-ийн дүрэм”-ийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Н.БЭГЗ





ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

ШУТИС-ийн Захиргааны бүтэц, зохион
байгуулалтыг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36.12.2, Дээд боловсролын тухай хуулийн 12.1.5, ШУТИС-ийн дүрмийн 3.6.2, Удирдах зөвлөлийн дүрмийн 3.1.7, ШУТИС-ийн Захирлын санал, Удирдах зөвлөлийн 2017 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. ШУТИС-ийн хөгжлийн бодлого, хэрэгжилтийг хангах, захиргааны удирдлагын үйл ажиллагааг сайжруулах, үргүй зардлыг бууруулах зорилгоор 2017 оны 5 дугаар сарын 16-ны өдрөөс Шинжлэх ухаан технологийн их сургуулийн захиргааны бүтцийг нэгдүгээр хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Шинжлэх ухаан технологийн их сургуулийн захиргааны бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн баталсантай холбогдуулан 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс ажлын үндсэн чиг үүрэг өөрчлөгдсөн хоёрдугаар хавсралтад заасан удирдах албан тушаал, газар, нэгжийг татан буулгаж, мөн өдрөөс шинэчилсэн бүтцийн дагуу, удирдах албан тушаал, газар, нэгжийг гуравдугаар хавсралтад зааснаар өөрчлөн байгуулсугай.
3. Бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийн дагуу их сургуулийн дэд захирал, захиргааны газар, нэгжийн чиг үүрэг, орон тоо, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн баталж, ажлаас чөлөөлөх, томилон ажиллуулах асуудлыг холбогдох хуулийн хүрээнд шийдвэрлэхийг ШУТИС-ийн захирал /Б.Очирбат/-д үүрэг болгосугай.
4. Захиргааны бүтэц, зохион байгуулалт шинэчлэгдсэнтэй холбогдуулан ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2015 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн “ШУТИС-ийн захиргааны бүтцийг батлах тухай” 03 тоот тогтоолын хавсралтын захиргаа, удирдлагын нэгж, менежментийн хувьд бие даан ажиллах, дэмжих нэгжийн бүтцийг хүчингүй болсонд тооцсугай.
5. Тогтоолын хэрэгжилтийн үр дүнг Удирдах зөвлөлийн даргад танилцуулахыг ШУТИС-ийн захирал /Б.Очирбат/-д даалгасугай.

ДАРГА  Н.БЭГЗ





ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2017 оны 06 сарын 12 өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12.3 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дахь заалт, Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалт, Удирдах зөвлөлийн 2017 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэнгийн 2015 оны санхүүгийн тайлан балансад авлагаар бүртгэгдсэн 57.132.000 /тавин долоон сая нэг зуун гучин хоёр мянга/ төгрөгийг авлагын данснаас хасч бүртгэлийн алдааг залруулахыг Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн захирал /Т.Төрмөнх/, ахлах нягтлан бодогч /Т.Болормаа/ нарт даалгасугай.
2. Санхүүгийн бүртгэл тооцоондоо нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, олон улсын стандарт, холбогдох дүрэм, журмыг мөрдөж ажиллахыг бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн захирал, нягтлан бодогч нарт даалгасугай.
3. Санхүү, нягтлан бодох бүртгэлийн ажлын хариуцлагыг дээшлүүлэх талаар зохих арга хэмжээг авч ажиллахыг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захирал /Б.Очирбат/-д даалгасугай.

ДАРГА



Н.БЭГЗ



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2017 оны 06 сарын 12 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

Элсэлтийн хяналтын тоо батлах тухай

Монгол Улсын Дээд боловсролын тухай хуулийн 7.2 дахь хэсэг, Удирдах зөвлөлийн 2017 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн хурлын тэмдэглэл, ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн 2017 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2017-2018 оны хичээлийн жилийн бакалаврын элсэлтийн хяналтын тоог хавсралтаар баталсугай.
2. Хяналтын тоонд багтаан элсэлтийн үйл ажиллагааг зохих журмын дагуу зохион байгуулахыг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захирал /Б.Очирбат/-д даалгасугай.

ДАРГА  Н.БЭГЗ

